



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 05 сарын 31 өдөр

Дугаар А/439

Булган сум

**Гүйцэтгэгчид гэрээ байгуулах
эрх олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээнд тусгасан Хөгжимт жүжгийн театрын тохижилт, техник хэрэгсэл нийлүүлэх нийлүүлэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны 2023 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн хурлын зөвлөмжийн дагуу нийлүүлэгчээр шалгарсан “Монтех дистрибьюшн” ХХК-тай 97 671 860 /Ерэн долоон сая зургаан зуун далан нэгэн мянга найман зуун жар/ төгрөгөөр гэрээ байгуулахыг эрхийг Хөгжимт жүжгийн театр (Ж.Халиунаа)-т олгосугай.

2. Нийлүүлж буй бараанд чанарын болон хугацааны хяналт тогтмол тавьж, хүлээн авахыг Хөгжимт жүжгийн театр (Ж.Халиунаа)-т үүрэг болгосугай.

3. Гэрээнд заасан барааг холбогдох хууль тогтоомж, стандарт, техникийн тодорхойлолтын дагуу нийлүүлж хүлээлгэн өгөхийг “Монтех дистрибьюшн” ХХК-ийн захирал (Б.Ууганболд)-д даалгасугай.

4. Тус барааг хууль, журам, гэрээний дагуу Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Д.Батцогт)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ

6323010438